

Сумъягийн
**СҮХБААТАР**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас жагсаалтаар нэр дэвшигч**

1973 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр, хоёр охины хамт амьдардаг.

Мандалговь хотын 10 жилийн 1-р сургуулийг 1990 онд онц төгсөж, МУИС-ийн Зөвлөлтийн инженерийн бэлтгэл ангид элсэн орсон. 1991-1994 онд МУИС-ийн ОУХДС-ийн англи хэлний ангид суралцаж байгаад Украйн улсын Киев хотын ОУХДС-д шилжин суралцаж 1999 онд олон улсын эрх зүйн бакалавр зэрэгтэй төгссөн. 2003-2004 онд хууль зүйн ухааны магистрын зэрэг, 2005-2009 онд хууль зүйн ухааны докторын зэрэг хүртсэн. Эдгээр эрдмийн ажлаа Японы эзэн хааны байгуулсан Кюшюгийн их сургуульд англи хэл дээр хамгаалсан.

МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Сургалтын төвийн эрхлэгчээр ажиллаж байсан. Одоо Дундговь аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Монгол Ардын Намын Хорооны даргаар ажиллаж байна. Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн, өмгөөлөгчдийн мэргэшлийн хорооны гишүүн, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал боловсруулах эрдэмтдийн багийн гишүүнээр тус тус ажиллаж байлаа.



Оргын
**БАТ-ЭРДЭНЭ**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Гурвансайхан суманд нэр дэвшигч**

1976 онд Дундговь аймагт төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг.

1984-1994 онд Дундговь аймгийн 10 жилийн 2-р сургууль, 1994-1998 онд МУБИС-д Физик, байгаль шинжлэлийн багш мэргэжлээр суралцаж төгссөн.

1998-2006 онд Дундговь аймгийн "Эрдмийн далай" цогцолбор сургуульд физикийн багш, 2006-2009 онд Гурвансайхан сумын сургуулийн захирал, 2009 оноос Дундговь аймгийн Монгол Ардын Намын хорооны тэргүүн дэд даргаар ажиллаж байна.

2008 онд Эх орны төлөө медаль, 2008 онд Аймгийн тэргүүний залуу өргөмжлөл, 2010 онд Боловсролын удирдах ажилтан хүндэт тэмдэг, 2010 онд Монгол Ардын Намын 90 жилийн ойн медаль, 2011 онд Боловсролын байгууллагын 90 жилийн ойн медаль, 2011 онд Аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн медаль, Монгол Ардын Намын тэргүүний ажилтан, 2012 онд Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан.



аатарын
**ГАНТОГТОХ**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас жагсаалтаар нэр дэвшигч**

1970 онд Мандалговь хотод төрсөн. Ам бүл 5. Эхнэр хүүхдийн хамт амьдардаг. Аймагтаа бага дунд сургууль төгсөөд, 1991-1996 онд ХААИС-д суралцан малын их эмч мэргэжил эзэмшсэн бөгөөд 2008-2009 онд бизнесийн удирдлага сэдвээр магистрын зэрэг хамгаалсан.

1998 оноос хувиараа хөдөлмөр эрхлэж байгаад 2005 оноос Шувуутай хийморь ХХК-ыг байгуулан захирлаар нь ажиллаж байна. Тус компанийг байгуулсанаар үндсэн болон гэрээт ажилчин 21 хүнийг ажлын байртай болгосон байна.

2011 оноос аймгийн МАН-ын дэд даргаар сонгогдон ажиллаж байна. Шувуутай хийморь ХХК нь 2009 онд сумын тэргүүний хамт олон, 2010 аймгийн тэргүүний хамт олон, 2009 онд аймгийн Шилдэг аж ахуйн нэгж болсон.

МЗХ-ны Алтан Од, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медалиар шагнагдсан.



Номхондоржийн
**МЭНДСАЙХАН**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас жагсаалтаар нэр дэвшигч**

1974 онд Сайнцагаан суманд төрсөн. Эдийн засагч, бараа судлаач мэргэжилтэй. Нөхөр 3 хүүхдийн хамт амьдардаг.

1990-1993 онд Зах зээлийн коллеж, 1997-2001 онд Өлзийт дээд сургууль, 2011 оноос МИУС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж байна.

2000 оноос БМБХ ХХК үүсгэн байгуулж захирлаар нь ажиллаж байна. Одоогоор ШТС, авто угаалга, засварын газар, зочид буудал, ресторaны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай хамт олон 2009 онд Сайнцагаан сумын Тэргүүний хамт олон , 2010 онд Мандалговь хотын өнгө төрхийг тодорхойлогч байгууллага, 2011 онд аймгийн Тэргүүний хамт олноор шалгарсан. Цаашид бид улсын тэргүүний хамт олон болох зорилт тавин ажиллаж байна.

2008-2012 онд Сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон. Аймгийн Монгол Ардын Намын хорооны тэргүүлэгч, Аймгийн Нийгмийн Ардчилал Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүлэгч, Аймгийн Зүүний хүчний холбооны тэргүүлэгчээр ажиллаж байна.



оовонгийн
**БОЛД**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас жагсаалтаар нэр дэвшигч**

1957 онд Увс аймгийн Өндөрхангай суманд төрсөн. Ам бүл 2.

1965-1975 онд бүрэн дунд боловсрол, 1975-1980 онд МУИС-д суралцаж барилгын инженер, 1987-1989 онд Намын дээд сургуульд суралцаж улс төр судлаач мэргэжил ту тус эзэмшсэн.

1980-1986 онд аймгийн барилгын зураг төслийн товчоонд ерөнхий инженер, 1989-1990 онд ТТБарилга трестед намын үүрийн дарга, 1990-1996 онд ТТБарилга трестийн орлогч дарга, 1996 оноос "Чандмань Дундговь" ХХК-ын захирлаар ажиллаж байна.

Монгол улсын Тэргүүний барилгачин, Байгаль орчны тэргүүний ажилтан цол тэмдэг, Ардын Хувьсгалын 80, 90 жилийн ойн медалиар шагнагдсан.



эмчигийн
**ГАНБАТ**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас жагсаалтаар нэр дэвшигч**

1976 онд Сайнцагаан суманд төрсөн.

Ам бүл 4, эхнэр хүүхдийн хамт амьдардаг.

1984-1994 онд Мандалговь хотын арван жилийн 2-р дунд сургуульд суралцаж төгссөн. 2009 оноос "Засагт хан" дээд сургуульд эчнээгээр суралцаж байна.

1998 оноос хувиараа хөдөлмөр эрхлэн, 2008 оноос "Хүрээн ус" ХХК-ийг байгуулан захирлаар нь ажиллаж байна.

2009 онд "Аймгийн тэргүүний бизнесмен"-ээр шалгарсан. 2010 онд Аймгийн хүндэт тэмдэгээр шагнагдсан.



## Мандраагийн **СОСОРБУРАМ**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Дэрэн суманд нэр дэвшигч**

1952 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрсөн. Ам бүл 4. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг.

1964-1972 онуудад Дэлгэрцогт суманд 8 жилийн дунд сургууль, 1972-1974 онд Мандалговь хотын 10 жилийн сургуулийг төгссөн. 1974-1979 онд ХААДСургуулийг (хуучин нэрээр) мал зүйч мэргэжлээр төгссөн. Дээд боловсролтой.

1979-1980 онд Өвөрхангай аймгийн Тарагт суманд дахь ЭМУСтанцад эрдэм, шинжилгээний ажилтан, 1980-1990 онуудад Дундговь аймгийн ХААУГазарт мэргэжилтэн хэлтсийн дарга, аймгийн ерөнхий Зоотехникч, ҮСУСтанцын дарга, 1990-2000 онд Дэрэн сумын Найрамдал нэгдэл, Наран-Хөгцтий хоршооны дарга, компаны захирал 2000 оноос одоог хүртэл Дэрэн сумын Засаг даргаар ажиллаж байна. "Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон"

"Алтан гадас одон" "ХХАА-н тэргүүний ажилтан" "НХДЗөвлөлийн тэргүүний нэгдэлчин" "Байгаль орчны тэргүүний ажилтан", "Аймгийн тэргүүний ажилтан" цол тэмдэг, одон медиалаар шагнагдсан.



## атжаргалын **ДОРЖСҮМБЭР**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Говь-Угтаал суманд нэр дэвшигч**

1977 оны 12 сарын 28-нд Дундговь аймгийн Мандалговь хотод төрсөн. Эхнэр Сүхбаатарын Ууганбаяр хоёр хүүгийн хамт амьдардаг.

1995 онд Дундговь аймгийн 10 жилийн 2-р сургууль төгсөж бүрэн дунд боловсрол, 1999 онд Нийгэм-Эдийн Засгийн дээд сургуулийг Социологич-Нийгмийн сэтгэл зүйч мэргэжлээр төгссөн. 2009 онд Удирдлагын Академийн Төрийн алба удирдлагын сургуулийн мэргэшүүлэх хөтөлбөрөөр суралцаж төгссөн. 2012 оноос Чингис хаан дээд сургуулийн магистрантурт суралцаж байна.

1999-2003 онд НЭЗДС, МХБДСургуульд багш, 2004-2007 онд Дарь Эхийн Далай ХХК-ны менежер, 2009-2010 онд Дундговь аймгийн Маркетинг, Социологийн судалгаа мэдээллийн төвийн захирал, 2010-2011 онд Аймгийн МАНамын хорооны сургалт, судалгаа хариуцсан улс төрийн ажилтан, 2011 оноос Говь-Угтаал сумын Засаг даргын орлогч, Дунд сургуулийн захиралаар ажиллаж байна.

Аймгийн Маркетинг, Социологийн судалгаа мэдээллийн төв ТББ-ын УЗГишүүн, Монголын Эрэгтэйчүүдийн Холбооны Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн гишүүн, Говь-Угтаал сумын Боржигон Угтуулын Эрчүүдийн Холбооны УЗГишүүн. Орчин цагийн боловсролын байгууллага үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойн медаль, Дундговь аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн медаль, Монгол Ардын Нам байгуулагдсаны 90 жилийн ойн медалиар тус тус шагнагдсан.



## атцоодолийн **БОЛДБААТАР**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Баянжаргалан суманд нэр дэвшигч**

1973 онд төрсөн, ам бүл 3, эхнэр хүүхдийн хамт амьдардаг. 1981-1989 онд Ерөнхий боловсролын дунд сургууль,1989-1991 онд ЗХУ-ын Казакстаны Рудный хотод Техник мэргэжлийн сургууль, 2010 онд Удирдлагын Академийн Бизнесийн удирдлагын сургуулийг тус тус төгссөн.

1997 онд "Аргатай"ХХК байгуулж орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, ард иргэдэд чанартай үйлчилгээг үзүүлэхийг гол зорилгоо болгон хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлт болон ажлын байр нэмэгдүүлэх төр засгийн бодлогыг байнга дэмжиж, орлого багатай иргэдийг ажлын байраар ханган ажиллаж байна.

2004 онд Тэргүүний ажил олгогч, 2005 онд Тэргүүний татвар төлөгч, 2006 ондТэргүүний ажил олгогч, 2007 онд Шилдэг хандивлагч, 2008 онд Шилдэг бизнесмен, 2009 онд Аймгийн шилдэг 10 ААН-ийн нэг, 2009-2011 онд. Шилдэг татвар төлөгч 2009 онд Аймгийн Монгол Ардын Намын хорооны шилдэг хандивлагч, 2012 онд МЗХ-ны "Хөдөлмөрийн алдар" алтан медалиар тус тус шагнагдсан.



## Сугирийн **ДЭЖИД**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Өндөршил суманд нэр дэвшигч**

Хулгана жилтэй,Өндөршил сумын Шар хад хэмээх газар төрсөн. Ам бүл 8-уул эхнэр, 6 охинтой.

Дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй.

Өндөршил суманд бригадын агент, бригадын дарга МХЗЭ-ийн үүрийн дарга, Намын үүрийн орлогч дарга, Луус сумын Хөдөлмөр нэгдлийн орлогч дарга, Говь-Угтаал сумын Худалдаа бэлтгэлийн ангийн дарга, Мандалговь хотын Худалдааны трестийн орлогч дарга, "Бөхт" ХХК-ны захирал зэрэг албыг хашиж, улсад 50 шахам жил хөдөлмөрлөсөн байна.

Тэрээр Алтан гадас одон, Биеийн тамирын тэргүүний ажилтан, ХАА-н тэргүүний ажилтан, Худалдааны тэргүүний ажилтан, Ардын Хувьсгалын 70,80,90 жилийн ойн медалиар шагнагдсан байна.



## Өлзий-Оршихын **АМГАЛАН**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Дэлгэрхангай суманд нэр дэвшигч**

1964 онд төрсөн. 3 хүүхэд төрүүлж өсгөсөн. Ам бүл 2, нөхрийн хамт амьдардаг.

1982 онд 10-р анги төгссөн. Нягтлан бодогч мэргэжилтэй.

1983-2000 онд Дэлгэрхангай сумын ХАА-н банкинд теллер, 2000 оноос "Толийн ундрага" ХХК байгуулан нягтлан бодогчоор нь ажиллаж байна. Тус компани нь сумын иргэдийг хямд үнэтэй, чанар сайтай өргөн хэрэглээний бараа, чанарын шаардлага хангасан нефтийн бүтээгдэхүүнээр хангах зорилго тавин ажиллаж, хэрэгжүүлж байна. "Толийн ундрага" ХХК сумын тэргүүний аж ахуйн нэгж, шилдэг татвар төлөгч хүүхдэд ээлтэй байгууллагаар удаа дараа шалгарсан. Дөрвөн иргэнийг ажлын байртай, тогтмол орлоготой болгосон.

Ардын Хувьсгалын 90 жилийн ойн мелаль, Ажил олгогч эдийн холбооны Хүндэт тэмдэг, Сангийн яамны 100 жилийн ойн Хүндэт тэмдэг, Аймгийн 70 жилийн ойн Хүндэт тэмдгээр тус тус шагнагдсан.



## амбабазарын **ЧАНДМАНЬ**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Сайхан-Овоо суманд нэр дэвшигч**

Эхнэр 2 хүү, 2 охин 2 ач, зээгийн хамт амьдардаг. 1974-1975 онд ЗХУ-ын Эрхүү хотын ИС-ийн орос хэлний бэлтгэл, 1975-1980 онд ЗХУ-ын Ташкент хотын ХААУИС-ийн усжуулалтын инженер, 1988-1991 онд МУИС-ийн ОУХДС-ийг анли хэлний хэлмэрч, 1998-2000 онд Герман улс Вейнсштафний ИС-ийн докторантурт, Япон, БНХАУ, ОХУ, Австри, БНСУ, Тайланд улсад мэргэжил дээшлүүлсэн. Хөдөө аж ахуйн ухааны доктор, профессор Шинжлэх Ухааны Үндэсний Академийн жинхэнэ гишүүн, Монгол улсын Зөвлөх инженер.

1980-1991 онд Усны ХТЭШ Институтэд инженер, ахлах, инженер, ЭША, группын дарга, хайгуулын товчооны дарга, 1991-1995 онд ХААЯ-д салбарын шинжлэх ухаан, технологийн менежер, 1995-2005 онд ХААИС-д багш, ахлах багш, 2005-2010 онд Усны хүрээлэнгийн захирал 2010 оноос Дундговь аймгийн Засаг даргаар ажиллаж байна.

Төрийн дээд шагнал "Алтан гадас" одон, Шинжлэх ухааны Тэргүүний ажилтан цол, тэмдэг, Боловсролын Тэргүүний ажилтан цол тэмдэг, ХАА-н Тэргүүний ажилтан цол, тэмдэг, Байгаль орчны Тэргүүний ажилтан цол, тэмдэг, Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, бусад ойн медалиар шагнагдсан.



## Ганбатын САМДАНЦООДОЛ

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Лууспан суманд нэр дэвшигч**

1983 онд Мандалговь хотод төрсөн. Ам бүл 4. Эхнэр, хүүхэд, эмээгийн хамт амьдардаг.

1991-1999 онд Луус сумын дунд сургууль, 1999-2001 онд "Эрдэмийн далай" цогцолбор сургууль, 2001-2005 онд Олон улсын эдийн засаг, бизнесийн дээд сургууль тус тус төгссөн.

2005-2007 онд Луус сумын боловсролын байгууллагуудын нягтлан бодогч, 2007-2009 онд Монгол шуудан банкинд тооцооны төвийн эрхлэгч, эдийн засагч, 2009 оноос Сумын Засаг даргын орлогчоор ажиллаж байна.

2009-2010 онд сумын МАН-ын үүрийн дарга, 2010 оноос сумын МАН-ын хорооны дэд дарга, 2009 оноос Суварга багийн ИНХ-ын тэргүүлэгч, 2007-2010 онд Сумын Залуучуудын Холбооны тэргүүлэгч гишүүн, 2010 оноос сумын НАМЗХолбооны тэргүүн.

МАН-ын Эх орны төлөө медаль, Нийгмийн ардчилалын төлөө медаль, МАН-ын тэргүүний ажилтан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Жуух бичиг, НАМЗХ-ын холбооны дээд шагнал "Алтан Од" медалиар шагнагдсан.



## Горын БАТЖАРГАЛ

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Эрдэнэдалай суманд нэр дэвшигч**

1964 онд Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд малчин ард Горын 8 дугаар хүү болон мэндэлсэн. Ам бүл 4-үүл амьдардаг. 1982 онд 10-р анги, "Засагт хан" Санхүү эдийн засгийн дээд сургууль төгссөн, Удирдлагын академийг бизнесийн удирдлагаар мэргэжил дээшлүүлсэн.

1982-1985 Хилийн цэргийн дугаар ангид цэргийн алба, 1985-1989 онд Эрдэнэдалай сумын хүүхдийн цэцэрлэгт аж ахуй, 1989-1991 онд "Залуус" хоршооллыг үүсгэн байгуулж төрөл бүрийн гар урлал, үйлчилгээ эрхэлж ажилласан. 1991-1998 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1998-2010 онд "Дэлгэрэх өнгөт" хоршооны дарга, 2010-2012 сумын Засаг даргын орлогч, 2012 оны 1 дүгээр сараас сумын Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна.

Хөдөлмөрийн хүндэт медаль "Худалдаа үйлчилгээний тэргүүний ажилтан" цол тэмдэг Худалдаа аж үйлдвэрийн яамны "Жуух бичиг" Аймаг, сумын Засаг даргын "Жуух бичиг"-ээр тус тус шагнагдсан. Ардын Хувьсгалын 90 жилийн ойн медалиар шагнагдсан.



## Жамбалсүрэнгийн МӨНХЧУЛУУН

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Сайнцагаан суманд нэр дэвшигч**

1984 онд Мандалговь хотод төрсөн. Ам бүл 7.

1992-2002 онд Дундговь Сайнцагаан сумын "Эрдмийн Далай" цогцолбор сургууль, 2002-2007 онд МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийг эрх зүйч, хуульч мэргэжлээр төгссөн, 2010 оноос МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн магистрантурт суралцаж байна. 2006-2010 онд Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэлгээний "Дамно" ХХК-ийн үүсгэн байгуулагч, хуулийн зөвлөх, захирал, 2010 оноос одоог хүртэл "NAB" группын хуулийн зөвлөх, 2012 оноос "Бодьсог Далай" ХХК-ийн захирал. 2002-2007 онд МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Эрдэм шинжилгээний "Энтимема" клубыг үүсгэн байгуулагч, удирдах зөвлөлийн гишүүн, 2003-2010 онд Дундговь аймгийн "Оюутан Залуучуудын холбоо"-ны удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга, тэргүүн, 2010 оноос одоог хүртэл "Говийн ногоон ирээдүй" ТББ-ын тэргүүн, 2010 оноос МАН-ын дэргэдэх "Нийгмийн ардчилал" Монголын оюутны холбооны удирдах зөвлөлийн гишүүн, 2010 оноос "Чагдаржав сан"-гийн нарийн бичгийн дарга, 2011 оноос Дундговь аймгийн "Нийгмийн ардчилал" Монголын оюутны холбооны тэргүүн.

2005 онд Монголын оюутны холбооны "Манлайлагч оюутан" алтан медаль, 2007 онд Монголын залуучуудын холбооны "Тэргүүний залуу" алтан медаль, 2010 онд Нийгмийн ардчилал Монголын залуучуудын холбооны шагнал "Алтан од" медаль, 2011 онд Дундговь аймгийн 70 жилийн ойн медаль , 2011 онд МАН-ын 90 жилийн ойн медаль, 2011 онд Дундговь аймгийн Засаг даргын жуух бичгээр тус тус шагнагдсан.



## Сүхээгийн ТҮВШИНЖАРГАЛ

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Сайнцагаан суманд нэр дэвшигч**

1986 онд Сайнцагаан суманд төрсөн. Эхнэрийн хамт амьдардаг.

2003 онд аймгийн төвийн "Эрдмийн Далай Цогцолбор" Сургууль, 2007 онд МУИС-ийн Нийгмийн Шинжлэх Ухааны Сургуулийг философич мэргэжлээр, 2010 онд Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын Академийг "Нийгмийн ухааны менежер" мэргэжлээр төгсөж, 2012 оноос Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг, Удирдлагын Академид Нийгмийн ухааны чиглэлээр магистрантурт суралцаж байна.

2007-2008 онд МАН-ын улс төрийн ажилтан, 2007-2008 онд аймгийн МАСЗХ-ны нарийн бичгийн дарга, 2008-2011 он аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Сайнцагаан сум хариуцсан мэргэжилтэн, 2011-2012 он мөн хэлтсийн хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн, 2012 оноос Сайнцагаан сумын Засаг даргын орлогчоор ажиллаж байна. Аймгийн МАН-ын хорооны гишүүн, Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын Холбооны тэргүүлэгчийн сонгуультай.

2012 онд Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны "Хүндэт жуух", 2011 онд Төрийн захиргааны салбарын оны шилдэг залуу, "Алтан сарнай"-н эзэн, 2011 онд Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газрын "Хүндэт өргөмжлөл", 2009 онд НАМЗХ-ны дээд шагнал "Алтан-Од" медалиар шагнагдсан.



## Чимиддуламын ГАНБААТАР

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Сайнцагаан суманд нэр дэвшигч**

1958 онд Луус суманд төрсөн, ам бүл 6, эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

1981-1984 онд Усны аж ахуйн техникум, 2000-2004 онд Засагт хан дээд сургуулийг төгсөж, төрийн захиргаа удирдлагын менежер мэргэжил эзэмшсэн, дээд боловсролтой. 1973-1977 онд аймгийн Материал техникийн хангамжийн удирдах газарт ачигч, 1977-1980 онд цэргийн алба хаасан. 1980-1992 онд Усны аж ахуйн удирдах газарт ажилчин, техникч, бригадын дарга, 1992-1994 онд Мандалговь сумын Засаг даргын Тамгын газарт жижүүр, 1994-1996 онд 2-р багийн туслах, 1996 оноос одоог хүртэл Сайнцагаан сумын 6-р багийн Засаг даргаар ажиллаж байна.

МАХН, МХЗЭ, МҮЭ, СнЗ-ийн диплом, Ардын хувьсгалын 80, 90 жилийн ойн медаль, Хөдөлмөрийн хүндэт медаль, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Статистикийн шилдэг ажилтан, Аймгийн хүндэт тэмдэг, Намын хүндэт тэмдэг, Алтан гадас одон, Нутгийн удирдлагын холбооны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан.



## Лэгшидийн БАТЦАГААН

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Сайнцагаан суманд нэр дэвшигч**

1957 онд Өвөрхангай аймгийн Хужирт суманд төрсөн. Эхнэр, хүүхэд, ээз нарын хамт амьдардаг.

1980 онд ХААИС-ийг малын их эмч мэргэжлээр төгссөн. 2010 онд БНХАУ-ын Хөх хотод мал эмнэлгийн чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн.

1980-1990 онд Өлзийт сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч, 1990-1992 онд Мал эмнэлгийн газрын паразитологч эмч, 1992-1999 онд Сайнцагаан сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч, 1999 оноос Тэгш Таван-Эрдэнэ ХХК-ний захирлаар ажиллаж байна.

Ардын Хувьсгалын 70, 80, 90 жилийн ойн медаль Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, ХХААЯ-ны Тэргүүний ажилчин цол, тэмдэг 2009 онд Алтан гадас одонгоор тус тус шагнадсан.



## Сандагийн **БУДЖАВ**

**Аймгийн ИТХ-д Монгол Ардын Намаас Сайнцагаан суманд нэр дэвшигч**

1979 онд Дундговь аймагт төрсөн. Ам бүл 4-үүл амьдардаг.

2011-2012 онд АНУ-ын Вашингтон ДС хот, Страйерийн Их сургуульд Олон Улсын бизнесийн удирдлагын магистр, 2012 онд АНУ-ын Бостон хот, Харвардын Их сургуульд Санхүү эдийн засгийн зах зээлийн мэргэшлийн курс, 2005-2006 онд Сингапур Улс, Раффлес Дээд сургууль, бизнесийн англи хэл,

1997-2001 онд Монгол Улс, ХААИС-ийн Эдийн засгийн факультетэд Эдийн засаг, математикийн бакалавр, 1987-1997 онд Дундговь аймаг, 10 жилийн 1-р сургуулийг төгссөн.

2001–2004 онд аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн, 2004–2005 онд аймгийн ЗДТГ-ын СТБХЗХэлтсийн үүл уурхай, хөдөө аж ахуй, дэд бүтэц, аялал жуулчлалын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, Хэлтсийн дарга, 2005-2008 онд аймгийн ЗДТГ-ын Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлого зохицуулалтын хэлтсийн дарга, 2008-2011 онд аймгийн Засаг даргын орлогчоор ажилласан.

Зам тээвэр, аялал жуулчлалын яамны тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнагдсан.



### *Сандагийн* ОД-ЭРДЭНЭ

1966 онд төрсөн. Ам бүл 5. Физикийн багш, эрх зүйч, төрийн удирдлагын менежер мэргэжилтэй. Аймгийн Ардчилсан намын дарга.



### *Авирмэдийн* ХАТАНТӨМӨР

1952 онд Дундговь аймгийн Хулд суманд төрсөн. Нөхөр хүүхдийн хамт амьдардаг. Хүний их эмч, улс төрч мэргэжилтэй. "Аясал" төрийн бус байгууллагын тэргүүн. Алтан гадас одонгоор шагнагдсан.



### *Арьяабалын* НАНСАЛМАА

1972 онд Сайнцагаан суманд төрсөн. Ам бүл 4. Номзүйч. Сурган хүмүүжүүлэх ухааны доктор, Аймгийн АЭХ-ны тэргүүн, Аймгийн Эмэгтэйчүүдийн нэгдсэн Холбооны тэргүүлэгч, МУСТА, Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан.



### *Мажаахүүгийн* ЭНХБАТ

1962 онд Улаанбаатар хотод төрсөн. Эдийн засагч улс төрч мэргэжилтэй.УТБА-ийн гүйцэтгэх захирал. Дундговь аймгийн Ардчилсан намын дэд дарга. Алтан гадас одонгоор шагнагдсан.



### *Мөнхтөрийн* АНХБАЯР

1988 онд төрсөн. Эхнэр, хүүгийн хамт амьдардаг. Улс төр судлаач мэргэжилтэй. "Итгэлт Мандал" ХХК-ийн Захирал. Сайнцагаан сумын АН-ын дэд дарга, аймгийн АЗХ-ны дарга, аймгийн ХАУТ-ын дарга, "Дундговь газар шороо хөдөлгөөн"-ий Тэргүүлэгч. Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, МЗХ-ны Тэргүүний залуу алтан медальтай.



### *Баасанжавын* ӨЛЗИЙХИШИГ

1975 онд Адаацаг суманд төрсөн. Ам бүл 5. Хүнсний технологийн инженер мэргэжилтэй. "Хөүл ланд"ХХК-ийн гүйцэтгэх захирал.



### *Буяагийн* БААТАРСҮРЭН

1967 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрсөн. Ам бүл 6. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.

1990 онд ХААДС-ийн байнгын курс, 2004 онд Орхон аймгийн ИБУТИС, 2007 онд Мандах бүртгэл дээд сургуулийг төгссөн. Удирдлагын менежер, Нягтлан бодогч мэргэжилтэй.

**Эрхэлсэн ажил:** 1985-1988 онд 0168-р ангид штабын бичээч, 1988-1990 онд "Нэгдмэл хөдөлгөөн" нэгдэлд малчин, 1990-1993 онд Бригадын дарга, тоо бүртгэгч, 1993-2004 онд Багийн засаг дарга, 2004-2009 онд ЗД-ын орлогч-төрийн сангийн төлөөлөгч, 2009 оноос ЗД-ын орлогчоор ажиллаж байна.

**Гавьяа, шагнал:** 2012 онд Хөдөлмөрийн хүндэт медаль, Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, 2007 онд Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан, 2002 онд МЗХ-ны "Тэргүүний залуу" алтан медаль, 2011 онд АХ-ын 90 жилийн ойн медаль, 2010 онд Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, 2001 онд Аймгийн тэргүүний ажилтан, 2008 онд Эрх чөлөөний одонгоор шагнагдсан.



### *Адъяагийн* ЭРДЭНЭЦОГТ

1972 оны наймдугаар сарын 27-нд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. Ам бүл 4, эхнэр, охин, хүүгийн хамт амьдардаг.

**Мэргэжил:**
Санхүүгийн менежер, эрх зүйч

**Төгссөн сургууль:**
1998-2001 онд Санхүү банкны "Өлзийт" дээд сургууль
2003-2008 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль

**Ажил эрхлэлт:**
1999 оноос одоог хүртэл "Зотолмандал" ХХК-ийн захирал
2003-2008 онд "Зотолхаан трейд" ХХК-ийн захирал
2002-2006 онд "Мон-Эпсон" ХХК-ийн ТУЗ-ийн дарга
2007-2010 онд "Жи-Мобайл" корпорацийн салбарын захирал
2011 оноос одоог хүртэл "Эко амралт" төслийн санаачлагч, зохицуулагчаар ажиллаж байна.

**Сонгуульт ажил:**
2003 оноос одоог хүртэл АН-ын Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүн
2001-2007 онд АЗХ-ны тэргүүн
2005 оноос Монголын өлөн гэдэс үйлдвэрлэгчдийн Холбооны тэргүүлэгч

**Гавьяа шагнал:**
Хөдөлмөрийн хүндэт медаль



### *Гүнсэнгийн* ПҮРЭВЖАВ

1956 оны зургадугаар сарын 18-нд Дундговь аймгийн Сайнцагаан сумын гуравдугаар багийн Дарцагт хэмээх газарт төрсөн. Эхнэр, хүүхэд, ач нарын хамт амьдардаг.

**Мэргэжил:**
Дулааны инженер, Төрийн удирдлагын менежер

**Төгссөн сургууль:**
1964-1974 онд Сайнцагаан сумын дунд сургууль
1974-1979 онд ЗХУ-ын Ростовна Дону барилгын техникум
1996 онд Удирдлагын академи

**Ажил эрхлэлт:**
1979-1983 онд Дундговь аймгийн НААҮ-ний газарт механикч
1983-1986 онд Ардын армийн 120-р ангид байлдагч, офицер
Эрчим Хүчний Нэгдсэн үйлдвэрт инженер
Сайнцагаан сумын ИТХ-ын дарга
"Мандалговь наран" ХХК-ийн Захирал

**Хэлний мэдлэг:**
Орос хэлтэй

**Гавьяа шагнал:**
1999 онд МСДН-ын дээд шагнал "Ардчиллын Од"хүндэт тэмдэг
2006 онд Монгол Улсын ХХААЯ-ны "Тэргүүний ажилтан" цол, тэмдэг
2010 онд Ардчиллын 20 жилийн ойн медаль
2010 онд "Алтан гадас"одон



## Цагаанхүүгийн
## МӨНХБАТ

1980 оны гуравдугаар сарын 30-нд Дундговь аймгийн Мандалговь хотод төрсөн. Ам бүл 4. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг.

**Төгссөн сургууль:**
1997 онд Сайнцагаан сумын 10 жилийн 2-р сургууль,
2002 онд ШУТИС-ын Компьютерийн Техник Менежментийн сургууль,
2010 онд Лектор төвийн CEO COLLEGE буюу Захирлуудын сургалт,

**Мэргэжил:**
Компьютерийн программ хангамжийн инженер. Баклавр зэрэгтэй.

**Ажил эрхлэлт:**
2001-2003 онд "Ньюфийл" ХХК-ийн инженер
2003-2005 онд "КЭСПА" ХХК-ийн захирал,
2007-2012 онд "САТИЛАЙТПОВЕР" ХХК-ийн ерөнхий захирал,
2012 оноос Барилга, Хот Байгуулалтын Сайдын зөвлөх.



## Жанлавын
## МӨНХТӨР

**Ургийн овог:** Харлаг
**Овог:** Жанлав
**Нэр:** Мөнхтөр
**Төрсөн он:** 1966
**Төрсөн газар:** Дундговь аймаг, Эрдэнэдалай сум
**Гэр бүл:** Эхнэр, 2 хүү, охин, 2 ач

**Боловсрол:** Дундговь төвийн 10 жилийн сургууль, Барилгын ТМС, ОХУ-ын Улаан-Үд хотын Үйлдвэр Сурганы Техникум, Санхүү банкны "Өлзий" дээд сургууль, Удирдлагын Академи, Болгар улсын Комсомолын дээд сургуулийн дээд курсыг тус тус төгссөн. БНСУ-ын Инчоны нисэхийн Академид мэргэжил дээшлүүлсэн.

**Мэргэжил:** Барилгын өрөгч-угсрагч, Мастер багш, Санхүүгийн болон Төрийн Удирдлагын менежер.

**Хашсан алба:** Дундговь аймгийн Барилгын ТМС-д мастер багш, Худалдааны байгууллагуудын ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн дарга, Итгэлт хоршооны дарга, "Итгэлт мандал" ХХК-ийн захирал, Мандалговь нисэх буудлын дарга.

**Сонгуульт ажил:** Аймгийн МоАХ-ын дарга, Аймгийн АН-ын хорооны гишүүн, Аймгийн Утга Зохиолын нэгдлийн эрхлэгч, Аймгийн Хэрэглэгчдийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэгийн тэргүүлэгч, "Дундговь Газар Шороо" хөдөлгөөний тэргүүлэгч, Сайнцагаан сумын ИТХ-ын төлөөлөгч, Эрдэнэдалай сумын Нутгийн Зөвлөлийн тэргүүлэгч.

**Гавьяа шагнал:** Алтан гадас одон, Тусгаар тогтнолын одон, Эрх чөлөөний одон, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, МЗХ-ны "Тэргүүний залуу" алтан медаль, Ардчилсан Хувьсгалын 20 жилийн ойн медаль, Аймгийн хүндэт тэмдэг, "Хүндэт хоршоологч" медаль, "Хүүхдийн төлөө" алтан медаль, Монголын Зохиолчдын Эвлэлийн 80 жилийн ойн медаль, Нутгийн Удирдлагын Холбооны дээд шагнал "Соёмбо" медаль.



## Намжилдоржийн
## БААСАНХҮҮ

1960 оны 12 дугаар сарын 15-нд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр, 3 хүүхдийн хамт амьдардаг

**АЖЛЫН ТУРШЛАГА:**
1988-1992 онд Дундговь аймгийн Хулд сумын ЕБС-д хичээлийн эрхлэгч
1992-1998 онд Дундговь аймгийн Хулд сумын ЗДТГ-д Тамгын газрын дарга, сумын засаг даргын орлогч, сумын засаг дарга
1998-2000 онд Дундговь аймгийн ЗДТГ-д аймгийн орлогч дарга
2000-2007 онд АНУ-ын ОУХА-аас санхүүжилтээр Мерси Кор ОУБ-ын хэрэгжүүлсэн Говийн санаачлага хөтөлбөрийн Дундговь аймаг дахь төлөөлөгч
1992-2004 хүртэл Дундговь аймгийн НӨУБ Иргэдийн төлөөлөгчдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдон аймгийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд оролцсон.
2007-2009 онд АНУ-ын ОУХА-аас санхүүжилтээр Мерси Кор ОУБ-ын хэрэгжүүлсэн "Говийн санаачлага" хөтөлбөрийн Бизнесийн хөгжилд төрийн байгууллагаас үзүүлэх дэмжлэгийн асуудал хариуцсан хөтөлбөрийн ажилтан
2009-2012 онд АНУ-ын Мерси Кор Монгол ОУБ-ын орон нутаг хариуцсан зохицуулагч

**БОЛОВСРОЛ:**
1969-1979 онд Ерөнхий Боловсролын Дунд Сургууль
1979-1982 онд Цэргийн Нэгдсэн Дээд Сургууль
1983-1988 онд Монгол Улсын Их Сургууль /Математикч/

**ЭРДМИЙН ЗЭРЭГ:**
2008 онд Монгол Улсын Их Сургууль /Математикийн ухааны магистр/
1988-1989 онд Сургуулийн Удирдах ажилтны курс БНМДИ
1992, 1996, 1998 онуудад Төрийн захиргааны Удирдах ажилтны курс

**ШАГНАЛ:**
2006 онд Дундговь аймгийн Тэргүүний ажилтан
2009 онд Дундговь аймгийн оны онцлох хүн
2009 онд Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль
2010 онд Алтан гадас одон
2012 онд Дундговь болон Ховд аймгуудын хүндэт тэмдэг



## Дашзэвгийн
## БУДЖАВ

Дундговь аймгийн Говь Угтаал суманд 1972 онд төрсөн. **Боловсрол:** 1979-1980 онд 10 жилийн сургууль, 1980-1987 онд Цагаандэлгэр сумын найман жилийн дунд сургууль, 1987-1989 онд Говь-Угтаал сумын 10 жилийн дунд сургуулийг тус тус дүүргэсэн.

**Эрхэлсэн ажил:** 1994-1997 онд Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын нярав, 2000 онд худалдаа үйлчилгээний "Хайрхан Хонгор" ХХК-ийн захирлаар, 2004-2008 онд тус сумын 1-р багийн Засаг дарга, 2005 оноос Цагаандэлгэр сумын Залуучуудын Холбооны дарга, 2006 онд малчны "Өрнөх" бүлгийн ахлагч, 2007-2008 онд "Хайрхан" худалдаа үйлчилгээний төвийн барилга байгууламжийг шинээр барьж хүнсний дэлгүүр, цайны газар, авто засвар, дугуй засвар, 2009 онд үсчин гутал засварчин зэргийг нээн ажиллуулж, сумын Уяачдын холбооны тэргүүлэгчээр сонгогдож, 2008-2012 онд багийн Засаг даргаар улиран сонгогдсон. 2008 оноос аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

**Гавьяа шагнал:** МЗХ-ны "Хөдөлмөрийн алдар" алтан медаль, Ардын Хувьсгалын 90 жилийн ойн медаль, Сангийн яамны 100 жилийн хүндэт тэмдэг, Аймгийн хүндэт тэмдэг, Аймгийн 70 жилийн ойн медаль, Сумын Уяачдын Холбооны 15 жилийн ойн медаль, 2007 онд шилдэг төрийн албан хаагч, 2011 онд байгууллагын шилдэг ажилтанаар тус тус шагнагдсан.



## Шатарын
## ЭНХБАТ

Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт бригадын төв дээр 1964 оны дөрөвдүгээр сарын 06-нд төрсөн. Ам бүл 5, эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.

**Боловсрол:** 1972-1982 онд аймгийн төвийн 10 жилийн сургууль, 1982-1984 онд ЗХУ-ын /хуучнаар/ Красноярск хотын Ойн ТМС-ийг ойн техникч мэргэжлээр, 1990-1995 онд Улаанбаатар хотод ХААИС-ийг малын эмч мэргэжлээр, 2001-2003 онд Удирдлагын академийг Төрийн удирдлагын менежер мэргэжлээр тус тус дүүргэсэн.

**Сонгуульт ажил:** Дундговь аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч.

**Хийж байсан ажил, албан тушаал:** 1984-1990 онд аймгийн Ойн аж ахуй, мод боловсруулах үйлдвэрт техникч, 1995-1998 онд аймгийн Мал эмнэлгийн газар малын их эмч, 1998-2001 онд аймгийн ХАА-н газрын дарга, 1998-2003 онд мал эмнэлэг үйлчилгээний "Онги-Таван-Эрдэнэ" ХХК-ийн захирал, 2001-2006 онд аймгийн Ардчилсан намын нарийн бичгийн дарга, 2006 оноос одоог хүртэл "Наранцацралт сан"-гийн Дундговь аймаг дахь төлөөлөгчийн газрын захирал, 2008-2012 онд Дундговь аймгийн Өлзийт сумын засаг даргаар тус тус ажиллаж байна.